

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

---

ГАЗАР ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ. ГАЗРЫН БҮРХЭВЧИЙН ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН  
ҮЗҮҮЛЭЛТ

MNS ..... : 2021

Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР  
УЛААНБААТАР  
2021 ОН

## ӨМНӨХ ҮГ

Стандарт, Хэмжил Зүйн Газар (цаашид СХЗГ гэх) нь олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Тус газар нь үндэсний стандарт боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг.

Энэхүү стандартыг Монгол Улсын Засгийн газраас Үндэсний орон зайн өгөгдлийн талаар баримталж буй үзэл баримтлал, хөтөлбөрийн хүрээнд орон зайн өгөгдлийг цахимжуулах нэгдсэн систем бүхий геопорталын орон зайн өгөгдөл бүрдүүлэлт, солилцоотой холбоотой стандартын орчныг бий болгоход зориулсан өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлагыг энэхүү баримт бичигт тусган боловсруулав.

Стандарт боловсруулах ажлыг “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” сэдэвт төслийн хүрээнд стандарт боловсруулалтын багийн доктор Б.Сайнбуян, А.Түрүүтүвшин, доктор Б.Баяртунгалаг, мэргэшсэн инженер Э.Алтанбагана, З.Нямбаяр, Н.Болдбаатар нар хамтран гүйцэтгэв.

Геоботаникч доктор Б.Мандах редакц хийж, Монгол Улсын Их Сургууль Шинжлэх Ухааны Сургууль Байгалийн Ухааны Салбарын багш, доктор профессор П.Мягмарцэрэн шүүмжийг хийв.

Стандартыг боловсруулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хамт олон, Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны гишүүд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дэргэдэх орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн гишүүд болон бусад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн мэргэжлийн байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ стандартын төслийг ТХ-36/Газрын харилцааны техникийн стандартчиллын хорооны хурлаар хэлэлцэн зөвшилцсөн болно.

Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1-1:2006, MNS 1-2:2006–ийн дагуу хянаж, боловсруулав.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар хот 13348 ШХ-48

Утас: (976-51) 263860

Факс: (976-11) 458032

Цахим шуудан: [standardinform@masm.gov.mn](mailto:standardinform@masm.gov.mn)

Цахим хуудас: [www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn),

[www.masm.gov.mn](http://www.masm.gov.mn)

СХЗГ 2021

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын Төв байгууллага) -т байна.

**АГУУЛГА**

ОРШИЛ.....	1
1 Хамрах хүрээ .....	2
2 Норматив эшлэл .....	2
3 Нэр томъёо, тодорхойлолт .....	3
3.1 Үндсэн агуулгад хамаарах ойлголт .....	3
3.2 Атрибутын утгын төрөлд /Value Type/ хамаарах ойлголт.....	4
4 Техникийн шаардлага.....	5
4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага .....	5
4.2 Атрибутад тавигдах (норматив) шаардлага .....	7
4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага .....	8
4.4 UML диаграмм (норматив).....	8
4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага .....	8
A Хавсралт (норматив) – Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга .....	10
B Хавсралт (норматив) – Кодын жагсаалт .....	28
C Хавсралт (норматив) – UML диаграмм .....	47
D Хавсралт (норматив) – Өгөгдлийн чанар.....	52

## ОРШИЛ

Энэхүү стандартын зорилго нь байрлалд суурилсан орон зайн суурь өгөгдлийг нэгдсэн мэдээллийн системд оруулах, бүрдүүлэх, мэдээллийг тогтмол шинэчлэх, солилцох үйл ажиллагаанд баримтлах өгөгдлийн сангийн бүтэц, агуулга, техникийн шаардлагыг бүрэн хэмжээнд тодорхойлох явдал юм.

Стандартыг баримталсны үр дүнд геопорталаар дамжуулан байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээллийн цахим үйлчилгээнүүдийг хэрэглээнд нэвтрүүлэх, нэгдсэн мэдээллийг нэг эх үүсвэрээс ашиглах, үйл ажиллагааны суурь нөхцөлийг бүрдүүлэх, эрчимтэй хөгжих боломжийг олгоно.

Энэхүү стандарт нь нэг талаас орон зайн өгөгдлийн санг хариуцагч байгууллага нөгөө талаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй хамаарал бүхий үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, эрдэм шинжилгээний байгууллага, хувь хэрэглэгч нарын хооронд үүсэх өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, шинэчлэх, хадгалах, солилцох бүх харилцаанд үйлчилж нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход ашиглах үндсэн баримт бичиг болно.

Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах Европын орон зайн мэдээллийн дэд бүтэц INSPIRE (Infrastructure for Spatial Information in Europe) системийн техникийн тодорхойлолт, олон улсын стандартын байгууллага (ISO)-ын TX 211 (ISO/TC 211-Geographic information/Geomatics) -с гаргасан ISO 19100 цуврал стандартуудын үзүүлэлт, шаардлагад тулгуурлаж, Монгол Улсад мөрдөж буй стандарт, норм, дүрэм, журам, орон зайн суурь өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэл болгон боловсруулав.

Мөн орон зайн суурь өгөгдлийн техникийн шаардлагуудыг мэдээллийн сангийн загварыг дүрслэх Загварчлалын Нэгдмэл Хэл (UML-Unified Modeling Language) -ийн дагуу нийцүүлэн боловсруулав.

Стандарт бүтэц нь орон зайн өгөгдлийн загвар, өгөгдлийн сангийн агуулга, орон зайн объектын төрөл, атрибут, кодын жагсаалт, UML диаграммаас бүрдэнэ.

Уг стандарт нь газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, тайлагнах, үйлчлэх зорилгоор өгөгдлийг системтэй, уялдаатай болгон бүрдүүлэхэд чиглэнэ.

Газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдөлд газрын бүрхцийн ангилал, бэлчээрийн хянан баталгаа хийхэд ашигладаг мэдээллүүд болох бэлчээрийн доройтлын ангилал, бэлчээрийн төлөв байдал, ашиглал нэг мэт мэдээг агуулна.

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код: 35.240.70

Газар зүйн мэдээлэл. Газрын бүрхэвчийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт	MNS ... 2021
Geographic information. Data specification on Land cover	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны ... дугаар сарын .....ний өдрийн ..... дугаар тушаалаар батлав

Энэхүү стандарт нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

Стандартын шаардлага нь заавал мөрдөгдөнө.

### 1 Хамрах хүрээ

Газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийн сан нь Монгол орны газрын бүрхэвчийн бүх элементүүд болох хиймэл гадаргуу, хөдөө аж ахуйн бүс, ой, намгархаг газар, гол, нуур зэрэг газрын гадаргуугийн физик болон бэлчээрийн ургамалжлын мэдээлэл, ангиллыг дүрслэлийн дөрвөн багцаар дамжуулан үндсэн болон дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан болно.

Энэхүү стандарт нь газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, стерео төрлүүд, атрибут мэдээллийн шаардлага, UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language), өгөгдлийн чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлоход хамаарна.

Монгол улсын нийт газар нутгийн хэмжээнд газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэх, хөтлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжид хамаарна.

### 2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

*ISO/TS 19103:2005, Газар зүйн мэдээлэл – Ойлголтын схемийн хэл;*

*ISO 19107: 2005, Газар зүйн мэдээлэл – Орон зайн схем;*

*ISO 19108: 2005, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем;*

*ISO 19108-c, 2002/Cor 1: 2006, Газар зүйн мэдээлэл – Цаг хугацааны схем, Техникийн засвар 1;*

*ISO 19109:2005, Газар зүйн мэдээлэл – Хэрэглээний схемийн дүрмүүд;*

*ISO 19111: 2007, Газар зүйн мэдээлэл – Орон зайн суурь солбицол;*

*ISO 19113: 2005, Газар зүйн мэдээлэл – Чанарын зарчим;*

*ISO 19123: 2007, Газар зүйн мэдээлэл – Багц давхаргын геометр ба функцийн схем;*

*ISO/TS 19127:2005, Газар зүйн мэдээлэл – Геодезийн код ба параметрууд;*

*ISO 19131:2007, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн бүтээгдэхүүний тодорхойлолт;*

*ISO 19138: 2006, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанарын хэмжүүр;*

*ISO/DIS 19156, Газар зүйн мэдээлэл – Ажиглалт ба хэмжилт;*  
*ISO/DIS 19157, Газар зүйн мэдээлэл – Өгөгдлийн чанар;*  
*MNS ISO/TS 19104:2012 Газарзүйн мэдээлэл - Нэр томьёо*

### **3 Нэр томьёо, тодорхойлолт**

Энэхүү стандарт ба түүнд холбогдох бусад стандартын хувьд дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

#### **3.1**

#### **Үндсэн агуулгад хамаарах ойлголт**

##### **3.1.1**

##### **орон зайн өгөгдөл**

газрын гадарга дээрх болон доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил зааг, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогц

##### **3.1.2**

##### **орон зайн суурь өгөгдөл**

харьцангуй урт хугацаанд үл өөрчлөгдөх, оролцогч талуудын хэрэгцээг нийтлэгээр хангах боломжтой, үндсэн буюу голлох мэдээлэл гэж тодорхойлсон орон зайн өгөгдөл

##### **3.1.3**

##### **өгөгдлийн багц**

өгөгдлийн сангийн нэг сэдэвчилсэн агуулгын хүрээнд багтах хэд хэдэн өгөгдлийн цуглуулга.

##### **3.1.4**

##### **стерео төрөл**

стандартад ашиглаж байгаа биет болон атрибутын ижил төстэй шинж чанарыг харгалзан үүсгэсэн ангилал, төрөл

##### **3.1.5**

##### **өгөгдөл төрөл**

ямар нэгэн геометр дүрслэл агуулаагүй, өгөгдлийн сэдэвчилсэн утга, хэмжээс, формат зэргийг илэрхийлэгч, хэд хэдэн үзүүлэлтүүдийг агуулсан төрөл.

##### **3.1.6**

##### **биет төрөл**

орон зайн агуулга бүхий геометр биетээр дүрслэгдсэн болон дүрслэх боломжтой биетийг илэрхийлэгч төрөл.

##### **3.1.7**

##### **мета өгөгдөл**

орон зайн өгөгдлийг хайх, бүртгэх, ашиглахад зориулагдсан орон зайн өгөгдлийн тухай мэдээллийн цогц (өгөгдлийн тухай өгөгдөл).

### 3.1.8

#### **кодын жагсаалт**

биетийн төрөл эсвэл өгөгдлийн төрлийн атрибутаг ашиглах урьдчилан боловсруулж үүсгэсэн ангиллын утгын жагсаалт.

## 3.2

### **Атрибутын утгын төрөлд /Value type/ хамаарах ойлголт**

#### 3.2.1

##### **Any**

тухайн хувьсагч руу ямар ч утгыг шууд ашиглах боломжтойг зааж өгсөн төрөл. [Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005-аас үзэж болно]

#### 3.2.2

##### **Area**

тухайн талбайн хавтгай эсвэл объектын гадаргуугийн эзэлж буй орон зайн хэмжээ. [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

#### 3.2.3

##### **Boolean**

тухайн мэдээлэл үнэн эсвэл худлаа гэсэн хоёр боломжит утгын аль нэгийг сонгоход хэрэглэдэг утгын төрөл юм (ихэвчлэн тийм бөгөөд үгүй гэсэн төрөл ашигладаг). [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

#### 3.2.4

##### **CharacterString**

тэмдэгтийн мөр. Бичиглэхэд ашигладаг тэмдэгтүүдийн жагсаалт. [Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005]

#### 3.2.5

##### **Date**

хугацааг заасан утгын төрөл. Огноо дангаараа болон огноо, цагийн хослол хэлбэрээр байж болно.

#### 3.2.6

##### **DateTime**

цаг хугацааг заасан утгын төрөл. Огноо, цагийн хослол хэлбэрээр байна. [Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005]

#### 3.2.7

##### **Decimal**

аравтын бутархайгаар илэрхийлэгдсэн бутархай тоон утга.

#### 3.2.8

##### **EX\_Extent**

биетийн орон зайн, босоо түвшний байрлалын болон цаг хугацааны талаарх мэдээлэл.

### **3.2.9**

#### **GM\_MultiSurface**

олон гадаргуу бүхий геометр биет. [Дэлгэрэнгүй мэдээллийг ISO/TS 19103:2005]

### **3.2.10**

#### **GM\_Object**

геометрийн объектын ангилал зүйн язгуур анги бөгөөд газар зүйн хувьд хамааралтай бүх геометрийн объектуудыг төлөөлдөг.

### **3.2.11**

#### **GM\_Point**

цэг бол зөвхөн нэг цэгээс бүрдэх геометр объектын өгөгдлийн үндсэн төрөл юм.

### **3.2.12**

#### **Integer**

тоон мэдээллийн хуваагдаагүй, задгай нэгж ашиглаагүй бүхэл утга байна. [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

### **3.2.13**

#### **Measure**

хэмжилтийн үр дүнд гаргасан хэмжигдэхүүний тоон утга. [Эх сурвалж: ISO/TS 19103:2005]

### **3.2.14**

#### **PT\_FreeText**


шинж чанар, агуулгыг тодорхойлж, тайлбарласан бичвэрийн мэдээлэл. Нэг болон олон хэлээр илэрхийлэх боломжтой.

## **4 Техникийн шаардлага**

### **4.1 Орон зайн өгөгдлийн сангийн бүтэц, агуулгад тавих (норматив) шаардлага**

**4.1.1** Орон зайн өгөгдлийн сан нь өгөгдлийг сэдэв, агуулгаас хамааруулан багцалсан хэлбэр болох “өгөгдлийн багц”, өгөгдлийн багц дотор агуулагдах стерео төрлүүд, өгөгдөл тус бүрийн дэлгэрэнгүй “атрибут”, атрибутад орох мэдээллийг төрөлжүүлж ангилсан “кодын жагсаалт” гэсэн хэсгүүдээс тогтсон бүтэцтэй (1-р зурагт тоймлон үзүүлэв) байхыг шаардана.





1-р зураг – Газрын бүрхэвчийн өгөгдлийн сангийн бүтэц, агуулга

**4.1.2** А хавсралтаар орон зайн өгөгдлийн сангийн багц тус бүрээр биет төрлүүд тэдгээрт хамаарах өгөгдөл төрөл, биет төрөл болон өгөгдөл төрлийн атрибут, атрибутын талбарт оруулах утга болон утгын төрлийн норматив шаардлагыг заана.

**4.1.3** В хавсралтаар кодын жагсаалтын норматив шаардлагыг тодорхойлно. Кодын жагсаалт нь атрибутын талбарт оруулах утгад ашиглах тогтмол утга бүхий ангилал гэж ойлгоно.

**4.1.4** Орон зайн өгөгдлийн сангийн багцад орсон өгөгдөл нь А хавсралтын А.1-р хүснэгтэд үзүүлсэн «биет төрөл», «өгөгдөл төрөл», «кодын жагсаалт» гэсэн стерео төрөлтэй байх норматив шаардлагыг хангана.

**4.1.5** Биет төрөл тус бүрийн орон зайн дүрслэлийг А хавсралтын А.1-р хүснэгтэд “Биетийн төрөл” баганад үзүүлсэн шаардлагын дагуу дүрсэлнэ.

**4.1.6** Өгөгдлийн нэрийг монгол, англи хэлээр нэрлэх бөгөөд мэдээллийг бүрдүүлэхдээ тодорхойлолтоор илэрхийлсэн агуулгын дагуу байхыг шаардана.

**4.1.7** Газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийн сан нь А хавсралтын А.1-р хүснэгтийн дагуу **Газрын бүрхэвчийн вектор өгөгдөл, Газрын бүрхэвчийн растер өгөгдөл, Бэлчээрийн ургамалжил** гэсэн 3 өгөгдлийн багцаас бүрдэнэ.

**4.1.8** Газрын бүрхэвчийн орон зайн өгөгдлийн санд 6 биет төрөл, 5 өгөгдөл төрөл агуулна.

## **4.2 Атрибутаг тавигдах (норматив) шаардлага**

**4.2.1** Өгөгдлийн атрибут мэдээлэл нь өгөгдөл тус бүрээр А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсэн норматив шаардлагыг хангана.

**4.2.2** Атрибут нь А хавсралтын А.2-р хүснэгтэд үзүүлсний дагуу атрибутын нэрийг монгол, /англи хэл/-ээр нэрлэх, “талбарт оруулах утга”, “утгын төрөл”, “тэмдэгтийн урт” гэсэн шаардлагыг хангахаас гадна тодорхойлолтод тусгасан мэдээллийн агуулгын дагуу бүрдүүлэлт, бичиглэлийг хийсэн байхыг шаардана.

**4.2.3** Орон зайн өгөгдлийн сангийн биет төрөл нь давтагдашгүй гадаад танигч атрибутыг агуулах шаардлагатай. Гадаад танигч /ExternalID/ нь орон зайн объектын танигч нь өгөгдлийн сангийн гадаад танигч үүсгэхэд ашиглах тусгай танигч код бөгөөд “дотоод танигч” /localID/, “нэрийн талбар” /namespace/, “танигчийн хувилбар” /versionID/ гэсэн 3 атрибутаас бүрдэнэ [Дэлгэрэнгүй мэдээллийг: ISO/TS 19103:2005].

**4.2.3.1 “Дотоод танигч /Local id/”** нь тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байхыг шаардана.

**4.2.3.2 “Нэрийн талбар /Name space/”** нь өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.

**4.2.3.3 “Танигчийн хувилбар /Version id/”** нь орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэсэн байхыг шаардана.

**4.2.4** Газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийн сан нь 4.2.4.1 – 4.2.4.2 –д заасан “Газар зүйн нэр” /Geographical Name/, “Хил зааг” /Boundary/ дэд өгөгдлийн сантай холбогдоно.

**4.2.4.1** “Газар зүйн нэр” /Geographical Name/ нь тухайн газар усны нэр “Нэр” /name/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Газарзүйн нэр» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газарзүйн мэдээлэл. Газар зүйн нэрийн өгөгдлийн үзүүлэлт MNS .....:2021” стандартаас авч ашиглана.

**4.2.4.2** “Байгалийн бүс бүслүүр” /Natural zone type/ нь тухайн “байгалийн бүс бүслүүр” /Natural zone type/ гэх атрибутаар холбогдох бөгөөд талбарт оруулах утгад «Байгалийн бүс бүслүүр» гэсэн «өгөгдөл төрөл»-ийг ашиглах бөгөөд түүний агуулгыг “Газарзүйн мэдээлэл. Хил заагийн өгөгдлийн үзүүлэлт MNS .....:2021” стандартаас авч ашиглана.

### **4.3 Кодын жагсаалтад тавих (норматив) шаардлага**

**4.3.1** А хавсралтын А.1-р хүснэгтэд кодын жагсаалтын тодорхойлолт, В хавсралтад кодын жагсаалтын кодын утга, түүний тодорхойлолтын дагуу норматив шаардлагыг хангана.

**4.3.2** Газрын бүрхэвчийн орон зайн өгөгдлийн санд 18 кодын жагсаалт агуулна.

**4.3.3** А хавсралтын А.2 хүснэгтэд заасан атрибутын талбарт оруулах утгад заасан кодын жагсаалтын дагуу ангиллын утгыг сонгож оруулах нөхцөлөөр ашиглана.

### **4.4 UML диаграмм (норматив)**

**4.4.1** Орон зайн объектын төрөл, атрибут, утгын төрөл, тэдгээрийн холбоосыг С хавсралтад үзүүлсэн UML диаграмм (Загварчлалын Нэгдмэл Хэл: UML-Unified Modeling Language)-ын дагуу өгөгдлийг загварчилна.

**4.4.2** Орон зайн өгөгдлийг загварчлах, боловсруулалтыг автоматжуулах, хэрэглээний схемд суурилсан өөр өөр түвшний өгөгдлийг уялдуулахад С хавсралтад үзүүлсэн UML диаграммыг ашиглана.

**4.4.3** С хавсралтад үзүүлсэн UML диаграммаас гадна газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийн сантай хамааралтай бусад орон зайн суурь өгөгдлийн сангийн UML диаграммыг ашиглахыг зөвшөөрнө.

### **4.5 Өгөгдлийн чанарт тавих (норматив) шаардлага**

**4.5.1** Өгөгдлийн чанарт тавигдах шаардлага нь газрын бүрхэвчийн суурь орон зайн өгөгдлийн нэгжийн чанарыг үнэлэх, баримтжуулах зорилготой чанарын элементүүдийн шаардлагыг D Хавсралтын D.1.1 - D.1.11-р хүснэгтэд үзүүлснээр

дагаж мөрдөнө. Эдгээр шаардлага нь ISO 19157 олон улсын стандартад заасан чанарын үзүүлэлтүүд бөгөөд энэ стандартад ерөнхий шаардлагуудыг дагаж мөрдөнө.

**4.5.2** Газрын бүрхэвчийн суурь орон зайн өгөгдлийн сангийн өгөгдлийн нэгж болох багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь өгөгдлийн чанарын дараах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангана.

**4.5.3** Газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийн сангийн өгөгдлийн багц, биет төрөл, өгөгдөл төрлүүд нь 4.5.3.1 - 4.5.3.4 –д заасан өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлтийг хангана.

**4.5.3.1 Бүрэн бүтэн байдал** өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлт нь өгөгдлийн багц, орон зайн объектын төрлийн түвшинд илүү эсвэл дутуугүй байх шаардлагатай.

**4.5.3.2 Байршлын нарийвчлал** өгөгдлийн чанарын шалгуур үзүүлэлт нь өгөгдлийн багц, орон зайн объект, орон зайн объектын төрлийн түвшинд байршлын алдаагүй байх шаардлагатай.

**4.5.3.3 Утга агуулгын нийцтэй байдал** өгөгдлийн багц, орон зайн объектын түвшинд ойлголт, домэйн, формат, топологийн алдаагүй, утга агуулгын хувьд нийцтэй байх.

**4.5.3.4 Сэдэвчилсэн нарийвчлал** өгөгдлийн багц, орон зайн объект, орон зайн объектын төрлийн түвшинд тоон болон тоон бус атрибут үнэн зөв нарийвчлал сайтай байх.

**ТӨГСӨВ**

## А Хавсралт

(норматив)

### Орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга

#### А. 1-р хүснэгт – Газрын бүрхэвчийн орон зайн суурь өгөгдлийн багц ба ангилал

##### А.1.1 Өгөгдлийн багц: Газрын бүрхэвчийн вектор өгөгдөл (Land cover vector)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Газрын бүрхэвчийн нэгж <i>/Land cover unit/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Газрын бүрхэвчийн өгөгдлийн багцын бие даасан элемент нь цэг эсвэл олон өнцөгтөөр илэрхийлэгдэнэ.
2	Газрын бүрхэвчийн судалгаа <i>/Land cover observation/</i>	«өгөгдөл төрөл» «data type»	-	Газрын бүрхэвчийн мэдээллийг тодорхой, газарт тайлбарлаж өгнө.
3	Газрын бүрхэвчийн ангиллын утга <i>/Land cover class value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газрын бүрхэвчийн ангиллын утга.

##### А.1.2 Өгөгдлийн багц: Газрын бүрхэвчийн растер өгөгдөл (Land cover raster)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Газрын бүрхэвчийн торлолын бүрхэц <i>/Land cover grid coverage/</i>	«биет төрөл» «feature type»	Грид	Газрын бүрхэвчийн өгөгдлийн растер дүрслэл.

##### А.1.3 Өгөгдлийн багц: Бэлчээрийн ургамалжил (Pasture vegetation)

Д/д	Өгөгдлийн нэр	Стереo төрөл	Биетийн төрөл	Тодорхойлолт
1	Бэлчээрийн ургамалжил <i>/Pasture vegetation/</i>	«биет төрөл» «feature type»	Полигон	Бэлчээрийн анги, нэгж талбарын ерөнхий мэдээллүүд, бэлчээрийн нөлөөлөл, эрүүл мэнд, хөнөөлд нэрвэгдсэн байдал, талхагдал зэргүүдийн мэдээллүүдийг оруулсан.

2	<b>Мониторингийн цэг</b> /Monitoring site/	«биет төрөл» «feature type»	Цэг	Мониторингийн цэгийн дүгнэлтийн чухал үзүүлэлтүүдийг оруулсан.
3	<b>Ургамалжилзүйн бичиглэл хийсэн цэг</b> /Description plot/	«биет төрөл» «feature type»	Цэг	Геоботаникийн буюу ургамалжилзүйн бичиглэл.
4	<b>Бэлчээрийн төлөв байдал</b> /Pasture condition/	«биет төрөл» «feature type»	Полигон	Бэлчээрийн төлөв байдлын мэдээллийг оруулсан.
5	<b>Ургамал нөмрөгийн ерөнхий бүрхэц</b> /Vegetation cover/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Ургамал нөмрөгийн тусгагийн бүрхэц.
6	<b>Ургамал нөмрөгийн төлөв байдал</b> /Vegetation status/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Ургамал нөмрөгийн төлөв байдал.
7	<b>Лабораторийн судалгаа</b> /Laboratory survey/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Лабораторийн судалгаа.
8	<b>Операторын нэр</b> /Operator name/	«өгөгдөл төрөл» «data type»	-	Судалгааг хийсэн аж ахуйн нэгж болон судлаачийн нэр.
9	<b>Ангиллын түвшин 1</b> /Classification level 1 value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Бэлчээрийн ангилал. Ангиллын түвшин 1.
10	<b>Ангиллын түвшин 2</b> /Classification level 2 value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Монгол орны бэлчээр хадлангийн ангилал. Ангиллын түвшин 2.
11	<b>Ангиллын түвшин 3</b> /Classification level 3 value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Монгол орны бэлчээр хадлангийн дэд ангилал. Ангиллын түвшин 3.
12	<b>Ангиллын түвшин 4</b> /Classification level 4 value/	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Монгол орны бэлчээр хадлангийн төрөл. Ангиллын түвшин 4.
13	<b>Бэлчээрийн ангилал</b>	«кодын жагсаалт»	Ангилал	Бэлчээрийн ангиллын кодын жагсаалт.

	<i>/Pasture classification value/</i>	«code list»		
14	<b>Бэлчээрийн ашиглалтын төрлийн ангилал</b> <i>/Types of pasture use value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Бэлчээрийн ашиглалтын төрлийн ангилал.
15	<b>Бэлчээрийн нөлөөллийн ангилал</b> <i>/Pasture impact value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Бэлчээрийн нөлөөллийн ангиллын кодын жагсаалт.
16	<b>Бэлчээрийн эрүүл мэнд ангилал</b> <i>/Pasture health value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Бэлчээрийн эрүүл мэндийн ангиллын кодын жагсаалт.
17	<b>Хортон мэрэгч ба хортон шавжийн хөнөөлийн үндсэн ангилал</b> <i>/Rodents and insect-pest type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хортон мэрэгч ба хортон шавжийн хөнөөлийн үндсэн ангилал.
18	<b>Хортон мэрэгч ба хортон шавжийн хөнөөлийн дэд ангилал</b> <i>/Rodents and insect-pest subtype value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Хортон мэрэгч ба хортон шавжийн хөнөөлийн дэд ангилал.
19	<b>Бэлчээрийн доройтлын ангилал</b> <i>/Land degradation value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Тухайн бүс нутгийн ургамлан бүлгэмдэл алдагдсанаар хөрс ил гарч үржил шимт хэсэг алдагдах, ургамлын бүтээмж багасах, тэтгэх даац буурах үзүүлэлтүүдийг хэлнэ.
20	<b>Бэлчээрийн талхлагдлын ангилал</b> <i>/Pasture degradation value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Бэлчээрийн талхлагдал.
21	<b>Бэлчээрийн төрх байдлын үзүүлэлтийн ангилал</b> <i>/Pasture condition value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Бэлчээрийн төрх байдлын үзүүлэлт.
22	<b>Ургамлын үндэсний ангилал</b> <i>/Plant root type value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Ургамлыг хөрсөнд бэхлэх, ус болон түүнд ууссан эрдэс бодисыг бусад эрхтэнд дамжуулах, шим бодисыг нөөцлөх үүрэгтэй эрхтэн.
23	<b>Арвийн ангилал</b> <i>/Species abundance value/</i>	«кодын жагсаалт»	Ангилал	Ургамлын арвийг Друдегийн ангиллаар ангилна.

		«code list»		
24	<b>Газрын гадаргын налуужилт</b> <i>/Surface slope value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Газрын гадаргын налуужилт.
25	<b>Ургамлын хөгжлийн үе шатны ангилал</b> <i>/Phenological stage value/</i>	«кодын жагсаалт» «code list»	Ангилал	Ургамлын хөгжлийн үе шатны ангилал.



## А. 2-р хүснэгт - Орон зайн өгөгдлийн дэд сангийн давхаргын атрибутын агуулга

### А.2.1 Өгөгдлийн багц - Газрын бүрхэвчийн вектор өгөгдөл (Land cover vector)

#### А.2.1.1 Биет төрлийн нэр: Газрын бүрхэвчийн нэгж (Land cover unit)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Геометр</b> /Geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Орон зайн объектоор бүрхэгдсэн орон зайн геометрийн дүрслэл.
2	<b>Дотоод танигч</b> /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	<b>Нэрийн талбар</b> /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	<b>Танигчийн хувилбар</b> /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	<b>Мэдээлэл бүртгэсэн огноо</b> /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	<b>Мэдээлэл засварласан, устгасан огноо</b> /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	<b>Газрын бүрхэвчийн судалгаа</b> /Land cover observation/	«Газрын бүрхэвчийн судалгаа» «Land cover observation»	-	-	Тодорхой цаг хугацаа, газар дээрх газрын бүрхэвчийн мэдээлэл.

#### А.2.1.2 Өгөгдөл төрлийн нэр: Газрын бүрхэвчийн судалгаа (Land cover observation)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Судалгааны огноо</b> /Observation date/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Судалгаатай холбоотой судалгаа хийсэн хугацаа.
2	<b>Судалгааны нэр</b> /Observation name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	200	Газрын бүрхэвчийн судалгааны нэр.
3	<b>Газрын бүрхэвчийн ангилал</b> /Land cover class/	<b>Газрын бүрхэвчийн ангилал</b> /Land cover class value/	Тэмдэгтийн мөр /Character string/	-	Газрын бүрхэвчийн төрөл, ангилал. Land cover class value - ийн ангиллын утгуудаас авна.
4	<b>Бүрхцийн хувь</b> /Covered percentage/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Ангиллын утгатай холбоотой LandCoverUnit-ийн хувь.

## А.2.2 Өгөгдлийн багц – Газрын бүрхэвчийн растер өгөгдөл (Land cover raster)

### А.2.2.1 Биет төрлийн нэр: Газрын бүрхэвчийн торлолын бүрхэц (Land cover grid coverage)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Геометр</b> /Geometry/	ГМ_Объект /GM_Object/	-	-	Орон зайн объектоор бүрхэгдсэн орон зайн геометрийн дүрслэл.
2	<b>Дотоод танигч</b> /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	<b>Нэрийн талбар</b> /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	<b>Танигчийн хувилбар</b> /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.

5	<b>Мэдээлэл бүртгэсэн огноо</b> /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	<b>Мэдээлэл засварласан, устгасан огноо</b> /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	<b>Хүчинтэй хугацаа</b> /Valid from/	Огноо /Date/	Огноо /Date time/	25	Үзэгдэл бодит байдалд оршин тогтнож эхэлсэн үе.
8	<b>Хүчингүй хугацаа</b> /Valid to/	Огноо /Date/	Огноо /Date time/	25	Үзэгдэл бодит байдалд оршихгүй болсон үе.
9	<b>Хамрах хүрээ</b> /Extent/	EX_Оронзайн хамрах хүрээ /EX_Extent/	-	-	Өгөгдлийн сангийн өргөтгөлийг агуулна.
10	<b>Хамрах хүрээний нэр</b> /Extent name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Газрын бүрхэвчийн хамрах хүрээний нэр.
11	<b>Бүрхцийн функц</b> /Coverage function/	«Давхаргын функц» «Coverage function»	-	-	Домэйний бүрхцийн байршил дахь цар хүрээний утгыг хэрхэн хүлээн авах тухай тайлбар.
12	<b>Домэйн багц</b> /Domain set/	Бүх төрөл /Any/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Координатын нэр томъёог тайлбарласан бүрхцийн домэйн хэлбэр.
13	<b>Цар хүрээний багц</b> /Range set/	Бүх төрөл /Any/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Бүрхцийн домэйний элементүүдтэй бүрхцийн үүргээр холбогдсон биет атрибутын утгын багц.
14	<b>Мета-өгөгдөл</b> /Meta data/	Бүх төрөл /Any/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Бүрхцийн нарийвчилсан мета өгөгдлийн хэрэглээ.
15	<b>Цар хүрээний төрөл</b> /Range type/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	150	Утгын цар хүрээний бүтцийн тайлбар.

### A.2.3 Өгөгдлийн багц – Бэлчээрийн ургамалжил (Pasture vegetation)

#### A.2.3.1 Биет төрлийн нэр: Бэлчээрийн ургамалжил (Pasture vegetation)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
-----	---------	----------------------	-------------	----------------	--------------

1	<b>Геометр</b> /Geometry/	ГМ_Олон талт гадаргуу GM_MultiSurface	-	-	Орон зайн объектоор бүрхэгдсэн орон зайн геометрийн дүрслэл.
2	<b>Дотоод танигч</b> /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	<b>Нэрийн талбар</b> /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	<b>Танигчийн хувилбар</b> /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	<b>Мэдээлэл бүртгэсэн огноо</b> /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	<b>Мэдээлэл засварласан, устгасан огноо</b> /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	<b>Үндсэн нэгж талбарын дугаар</b> /Parcel name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	25	Үндсэн нэгжийн талбар дугаар (B211600046 г.м)
8	<b>Талбай</b> /Area/	Талбай /Area/	Бутархай тоо /Decimal/	10	Судалгааны талбайн хэмжээ.
9	<b>Нэр</b> /Name/	«Газар зүйн нэр» «GeographicalName»	-	-	Газар усны нэр.

10	<b>Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн бүс</b> /Natural-territorial zone/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	30	Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн бүс. Жишээлбэл: Хангайн бүс, Говийн бүс гэх мэт.
11	<b>Байгалийн бүс, бүслүүр</b> /Nature zone/	<b>Байгалийн бүс бүслүүр</b> /Natural zone type value/	-	-	Хил заагийн дэд өгөгдлийн сангийн Natural zone type value кодын жагсаалтын ашиглана.
12	<b>Бэлчээрийн ангилал</b> /Pasture classification type/	<b>Бэлчээрийн ангилал</b> /Pasture classification value/	-	-	Pasture Classification Value -ийн ангиллын утгуудаас авна.
13	<b>Ангиллын түвшин 1</b> /Classification level 1 value type/	<b>Ангиллын түвшин 1</b> /Classification level 1 value/	-	-	Classification level 1 value -ийн ангиллын утгуудаас авна.
14	<b>Ангиллын түвшин 2</b> /Classification level 2 value type/	<b>Ангиллын түвшин 2</b> /Classification level 2 value/	-	-	Classification level 2 value -ийн ангиллын утгуудаас авна.
15	<b>Ангиллын түвшин 3</b> /Classification level 3 value type/	<b>Ангиллын түвшин 3</b> /Classification level 3 value/	-	-	Classification level 3 value -ийн ангиллын утгуудаас авна.
16	<b>Ангиллын түвшин 4</b> /Classification level 4 value type/	<b>Ангиллын түвшин 4</b> /Classification level 4 value/	-	-	Classification level 4 value -ийн ангиллын утгуудаас авна.
17	<b>Бэлчээрийн ашиглалтын төрөл</b> /Types of pasture use/	<b>Бэлчээрийн ашиглалтын төрлийн ангилал</b> /Types of pasture use value/	-	-	Types of pasture use value -ийн ангиллын утгуудаас авна.
18	<b>Бэлчээрийн нөлөөлөл</b> /Pasture impact type/	<b>Бэлчээрийн нөлөөллийн ангилал</b> /Pasture impact value/	-	-	Pasture impact value -ийн ангиллын утгуудаас авна.
19	<b>Бэлчээрийн эрүүл мэндийн ангилал</b> /Pasture health type/	<b>Бэлчээрийн эрүүл мэндийн ангилал</b> /Pasture health value/	-	-	Бэлчээрийн газрын гадарга ба хөрсний бохирдлын нэр Pasture health value -ийн ангиллын утгуудаас авна.
20	<b>Хортон мэрэгч ба хортон шавжийн хөнөөлийн үндсэн ангилал</b>	<b>Хортон мэрэгч ба хортон шавжийн хөнөөлийн үндсэн ангилал</b>	-	-	Rodents and insect-pest type value-ийн ангиллын утгуудаас авна.

	/Rodents and insect-pest type/	<b>/Rodents and insect-pest type value/</b>			
21	<b>Хортон мэрэгч ба хортон шавжийн хөнөөлийн дэд ангилал</b> /Rodents and insect-pest subtype value/	<b>Хортон мэрэгч ба хортон шавжийн хөнөөлийн үндсэн ангилал</b> <b>/Rodents and insect-pest subtype value/</b>	-	-	Rodents and insect-pest subtype value - ийн ангиллын утгуудаас авна.
22	<b>Бэлчээрийн доройтол</b> /Land degradation value/	<b>Бэлчээрийн доройтлын ангилал</b> <b>/Pasture over grazing value/</b>	-	-	Тухайн бүс нутгийн ургамал бүлгэмдэл алдагдсанаар хөрс ил гарч үржил шимт хэсэг алдагдах, ургамлын бүтээмж багасах, тэтгэх даац буурах үзүүлэлтүүдийг хэлнэ Pasture over grazing value -ийн ангиллын утгуудаас авна.
23	<b>Бэлчээрийн талхлагдал</b> /Pasture degradation type/	<b>Бэлчээрийн талхлагдлын ангилал</b> <b>/Pasture degradation value/</b>	-	-	Pasture degradation value -ийн ангиллын утгуудаас авна.
24	<b>Операторын нэр</b> /Operator name/	«Операторын нэр» «Operator name»	-	-	Тухайн судалгааны ажил гүйцэтгэсэн аж ахуй нэгж болон судлаачийн нэр

#### А.2.3.2 Биет төрлийн нэр: Бэлчээрийн төлөв байдал (Pasture condition)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Геометр</b> /Geometry/	GM_Олон талт гадаргуу GM_MultiSurface	-	-	Орон зайн объектоор бүрхэгдсэн орон зайн геометрийн дүрслэл.
2	<b>Дотоод танигч</b> /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг

					агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	<b>Нэрийн талбар</b> /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	<b>Танигчийн хувилбар</b> /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	<b>Мэдээлэл бүртгэсэн огноо</b> /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	<b>Мэдээлэл засварласан, устгасан огноо</b> /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	<b>Талбай</b> /Area/	Талбай /Area/	Бутархай тоо /Decimal/	10	Судалгааны талбайн хэмжээ.
8	<b>Өмнөх нэгж талбарын дугаар</b> /Before parcel name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	25	Өмнөх нэгжийн талбарын дугаар /903000301 г.м/
9	<b>Үндсэн нэгж талбарын дугаар</b> /Parcel name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр	25	Үндсэн нэгжийн талбар дугаар (B211600046 г.м)

			/Character string/		
10	<b>Бэлчээрийн ангилал</b> /Pasture classification type/	<b>Бэлчээрийн ангилал</b> /Pasture classification value/	-	-	Pasture Classification Value -ийн ангиллын утгуудаас авна.
11	<b>Бэлчээрийн төлөв байдлын үзүүлэлт</b> /Pasture condition type/	<b>Бэлчээрийн төлөв байдлын үзүүлэлтүүдийн ангилал</b> /Pasture condition value/	-	-	Pasture condition value -ийн ангиллын утгуудаас авна.
12	<b>Операторын нэр</b> /Operator name/	«Операторын нэр» «Operator name»	-	-	Тухайн судалгааны ажил гүйцэтгэсэн аж ахуй нэгж болон судлаачийн нэр

#### А.2.3.3 Биет төрлийн нэр: Мониторингийн цэгийн дугаар (Monitoring site)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Геометр</b> /Geometry/	ГМ_Цэг GM_Point	-	-	Орон зайн объектоор бүрхэгдсэн орон зайн геометрийн дүрслэл.
2	<b>Дотоод танигч</b> /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	<b>Нэрийн талбар</b> /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	<b>Танигчийн хувилбар</b> /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт



					бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	<b>Мэдээлэл бүртгэсэн огноо</b> /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	<b>Мэдээлэл засварласан, устгасан огноо</b> /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	<b>Нэр</b> /Name/	«Газар зүйн нэр» «GeographicalName»	-	-	Газар усны нэр.
8	<b>Мониторингийн цэгийн дугаар</b> /Monitoring id/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	25	Мониторингийн цэгийн дугаар (M1B650101-00001).
12	<b>Үндсэн нэгж талбарын дугаар</b> /Parcel name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	25	Үндсэн нэгжийн талбар дугаар (B211600046 г.м).
13	<b>Бэлчээрийн ангилал</b> /Pasture classification type/	<b>Бэлчээрийн ангилал</b> <b>/Pasture classification value/</b>	-	-	Pasture classification value -ийн ангиллын утгуудаас авна.
14	<b>Газрын гадаргын төрх байдал</b> /Surface type/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Газрын гадаргын төрх байдал.
15	<b>Чулуужилт</b> /Percent of rocky/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	5	Талбайн чулуужилтыг %-ар илэрхийлнэ.
16	<b>Ургамлын үндэс</b> /Plant root type/	<b>Ургамлын үндэсний ангилал</b> <b>/Plant root type value/</b>	-	-	Ургамлыг хөрсөнд бэхлэх, ус болон түүнд ууссан эрдэс бодисыг бусад эрхтэнд дамжуулах, шим бодисыг нөөцлөх үүрэгтэй эрхтэн. Plant root type value-ийн ангиллын утгуудаас авна.

17	<b>Өндөр</b> /Elevation/	«Өндөр» «Elevation»	-	-	Газрын гадаргаас босоо чиглэлд тооцсон абсолют хэмжигдэхүүний утга.
18	<b>Газрын гадаргын налуужилт</b> /Surface slope type/	<b>Газрын гадаргын налуужилт</b> /Surface slope value/	-	-	Surface slope value-ийн ангиллын утгуудаас авна.
19	<b>Операторын нэр</b> /Operator name/	«Операторын нэр» «Operator name»	-	-	Тухайн судалгааны ажил гүйцэтгэсэн аж ахуй нэгж болон судлаачийн нэр

#### А.2.3.4 Биет төрлийн нэр: Ургамалжилзүйн бичиглэл хийсэн цэг (Description plot)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Геометр</b> /Geometry/	ГМ_Цэг GM_Point	-	-	Орон зайн объектоор бүрхэгдсэн орон зайн геометрийн дүрслэл.
2	<b>Дотоод танигч</b> /Local ID/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Тухайн өгөгдлийг хариуцагч эрх бүхий этгээдийн үүсгэж өгсөн танигч, тоо болон үсгийг агуулсан давтагдашгүй дугаар байна.
3	<b>Нэрийн талбар</b> /Name space/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	100	Өгөгдлийн нэр эсвэл өгөгдөл хариуцагч эрх бүхий байгууллагын нэр.
4	<b>Танигчийн хувилбар</b> /Version ID/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын одоогийн үйлчилж буй танигчийн хувилбар. Дотоод танигч шинэчлэгдсэн тохиолдолд хэд дэх эсвэл хэзээний хувилбар болохыг илэрхийлэгч үзүүлэлт бөгөөд дэс дугаар эсвэл огноо хэлбэрээр бүртгэнэ.
5	<b>Мэдээлэл бүртгэсэн огноо</b> /Begin lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орон зайн өгөгдлийн

					багцад оруулсан эсвэл өөрчилсөн огноо болон цаг.
6	<b>Мэдээлэл засварласан, устгасан огноо</b> /End lifespan version/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Орон зайн объектын энэ хувилбарыг орлуулсан эсвэл орон зайн өгөгдлийн багцад ашиглахаа больсон огноо.
7	<b>Нэр</b> /Name/	«Газар зүйн нэр» «GeographicalName»	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Газар усны нэр.
8	<b>Бичиглэл хийсэн цэгийн дугаар</b> /Description plot number/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Бичиглэл хийсэн цэгийн дугаар
9	<b>Зүйлийн бүрэлдэхүүний тоо</b> /Number of species 1/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Тухайн судалгааны талбай /1м <sup>2</sup> / дотор ургаж байгаа бүх ургамлын жагсаалт юм.
10	<b>Зүйлийн бүрэлдэхүүний тоо</b> /Number of species 100/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Тухайн судалгааны талбай /100м <sup>2</sup> / дотор ургаж байгаа бүх ургамлын жагсаалт юм.
11	<b>Ургамлын тусгагийн бүрхэц</b> /Canopy cover percent 1/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Ургамлын газрын гадаргуу дээрх тусгалын проекц юм. “% 1м <sup>2</sup> ”-аар илэрхийлнэ.
12	<b>Ургамлын тусгагийн бүрхэц</b> /Canopy cover percent 100/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Ургамлын газрын гадаргуу дээрх тусгалын проекц юм. “% 1м <sup>2</sup> ”-аар илэрхийлнэ. “% 100м <sup>2</sup> ”-аар илэрхийлнэ.
13	<b>Халцгай газрын хэмжээний эзлэх хувь</b> /Percent of bareground/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Халцгай газрын эзлэх хувь,%
14	<b>Газрын гадаргын налуужилт</b> /Surface slope type/	<b>Газрын гадаргын налуужилт</b> /Surface slope value/	-	-	Surface slope value-ийн ангиллын утгуудаас авна.
15	<b>Хад чулууны эзлэх хувь</b> /Percent of stony/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Хад чулууны эзлэх хувь,%

16	<b>Талхлагдлын заагуур ургамлын тусгаг бүрхэц</b> /Vegetation cover of degradation/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Талхлагдлын заагуур ургамлын тусгаг бүрхэц, %
17	<b>Арви</b> /Species abundance type/	<b>Арвийн ангилал</b> /Species abundance value/	-	-	Ургамлын элбэгшлийг тодорхойлно. Друдегийн ангиллаар ангилна. Species abundance value-ийн ангиллын утгуудаас авна.
18	<b>Зонхилох ургамлын нэр</b> /Dominant plant name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Зонхилох ургамлын нэр.
19	<b>Тусгагийн бүрхэц</b> /Vegetation cover/	«Ургамал нөмрөгийн ерөнхий бүрхэц» «VegetationCover»			Тухайн талбайн бүрхэцийг илэрхийлэх ургамлын %-ийг бичнэ.
20	<b>Ургамал нөмрөгийн төлөв байдал</b> /Vegetation condition/	«Ургамал нөмрөгийн төлөв байдал» «Vegetation status»	-	-	Судалгааны талбайд ургаж буй ямар ургамал давамгайлж байгааг тодорхойлдог.
21	<b>Лабораторийн судалгаа</b> /Laboratory survey/	«Лабораторийн судалгаа» «Laboratory survey»	-	-	Хээрийн судалгаанаас авсан дээжийг лабораторид дэлгэрүүлэн судлах.
22	<b>Ургамлын хөгжлийн үе шат</b> /Phenological stage type/	<b>Ургамлын хөгжлийн үе шатны ангилал</b> /Phenological stage value/	-	-	Ургамлын ургаж эхлэхээс мөхөх хүртэлх үеийн эрхтэн үүслийн шинж хэлбэр. Phenological stage value-ийн ангиллын утгуудаас авна.
23	<b>Тоосжилт</b> /Dust/	Логик /Boolean/	Логик /Boolean/	5	Тоосжилттой үгүйг илэрхийлнэ.
24	<b>Мал, амьтны нөлөө</b> /Life stock influence/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	250	Мал, амьтны нөлөө.
25	<b>Мэрэгчдийн тархалт</b> /Distribution rodent/	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Мэрэгчдийн тархалт, тоо.
26	<b>Хортон шавжийн тархалт</b>	Бүхэл тоо /Integer/	Бүхэл тоо /Integer/	10	Хортон шавжийн тархалт, тоо.

	/Distribution insectpest/				
27	<b>Операторын нэр</b> /Operator name/	«Операторын нэр» «Operator name»	-	-	Тухайн судалгааны ажил гүйцэтгэсэн аж ахуй нэгж болон судлаачийн нэр

#### А.2.3.5 Өгөгдөл төрлийн нэр: Ургамал нөмрөгийн ерөнхий бүрхэц (Vegetation cover)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Буурцагтан</b> /Legume/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Буурцагтан,%
2	<b>Үетэн</b> /Grass/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Үетэн,%
3	<b>Улалж</b> /Carex/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Улалж,%
4	<b>Алаг өвс</b> /Forb/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Алаг өвс,%
5	<b>Шарилж</b> /Sage/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Шарилж,%
6	<b>Сонгинолог</b> /Allium/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Сонгинолог,%

#### А.2.3.6 Өгөгдөл төрлийн нэр: Ургамал нөмрөгийн төлөв байдал (Vegetation status)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Хорт ургамлын нэр</b> /Pestilent plant/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Хорт ургамлын нэр
2	<b>Нэн ховор, ховор ургамлын нэр</b> /Rare and very rare plant/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Нэн ховор, ховор ургамлын нэр
3	<b>Эмийн ургамлын нэр</b> /Medicinal plant/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Эмийн ургамлын нэр

#### А.2.3.7 Өгөгдөл төрлийн нэр: Лабораторийн судалгаа (Laboratory survey)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
-----	---------	----------------------	-------------	----------------	--------------

1	<b>1 га-гийн ургац</b> /Amount of yeild/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	1 га-гийн ургац, цн/га
2	<b>Тэжээлийн нэгж</b> /Forage unit/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Тэжээлийн нэгж, кг/тн
3	<b>NDVi-аар бодуулсан ургамлын бүрхэвчийн утга</b> / Biomass/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	NDVi-аар бодуулсан ургамлын бүрхэвчийн утга
4	<b>Нойтон ургац</b> /Wet yeild/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Нойтон ургац (ногоон массын жин) гр.м <sup>2</sup> талбайд
5	<b>Хуурай ургац</b> /Dry yeild/	Хэмжээс /Measure/	Бутархай тоо /Decimal/	10	Хуурай ургац (ногоон массын жин) гр.м <sup>2</sup> талбайд
6	<b>Чийгийн хангамж</b> /Moisture supply/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Чийгийн хангамж
7	<b>Усан хангамж</b> /Water supply/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	50	Усан хангамж

#### А.2.3.8 Өгөгдөл төрлийн нэр: Операторын нэр (Operator name)

Д/д	Атрибут	Талбарт оруулах утга	Утгын төрөл	Тэмдэгтийн урт	Тодорхойлолт
1	<b>Аж ахуйн нэгжийн нэр</b> /Organization name/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	70	Судалгааг хийсэн аж ахуйн нэгжийн нэр.
2	<b>Судлаачийн нэр</b> /Name of employee/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	70	Судалгааг хийсэн ажилтны нэр.
3	<b>Ажилтны албан тушаал</b> /Employee position/	Тэмдэгтийн мөр /Character string/	Тэмдэгтийн мөр /Character string/	70	Судалгааг хийсэн ажилтны албан тушаал.
4	<b>Судалгаа хийсэн хугацаа</b> /Investigation time/	Огноо /Date time/	Огноо /Date time/	25	Судалгаа хийсэн огноо.

## В Хавсралт

(норматив)

### Кодын жагсаалт

#### В.1 Өгөгдлийн багц - Газрын бүрхэвчийн вектор өгөгдөл (Land cover vector)

##### В.1.1 Газрын бүрхэвчийн ангилал – Land cover class value

Д/д	Ангиллын утга	Тодорхойлолт
1	<b>Мөнх цас, мөс</b> /glacier/	Мөсөн эсвэл байнгын цасан бүрхүүл бүхий газар.
2	<b>Өндөр уулын хад асга</b> /highMountainTaiga/	Уул нурууны чулуурхаг газраас булгарч нурсан хэсэг.
3	<b>Холимог ой</b> /mixedForest/	Ургамлын хэлбэржилт нь үндсэндээ мод, бут сөөг, бут сөөгийн дор байрладаг бөгөөд тэдгээр нь өргөн, шилмүүст, шилмүүст зүйлийн давамгай хэлбэртэй байдаг.
4	<b>Уулын хээр</b> /mountainSteppe/	Уулын хээр.
5	<b>Бутархаг хээр</b> /shrubland/	Бутлаг, модлог ургамал ихээр ургадаг хээр.
6	<b>Хээр</b> /steppe/	Хүн суурьшаагүй, айл хүнгүй алс зэлүүд газрыг ерөнхийд нь нэрлэх үг юм.
7	<b>Хуурай хээр</b> /drySteppe/	Хуурай хээр.
8	<b>Цөлийн хээр</b> /desertSteppe/	Чулуурхаг, шавранцар, зузаан элсэн хөрстэй тал хөндий.
9	<b>Говь цөл</b> /desert/	ургамал тачир сийрэг, усгүй шахам хээр тал газар ба байнгын хуурай амьсгалтай байгалийн бүс.
10	<b>Нүцгэн газар</b> /overgrazingLand/	Өвс ургамал муутай /хэт доройтсон/ газар.
11	<b>Элстэй газар</b> /sandyLand/	Элсээр хучигдсан газар.
12	<b>Нуга, намгархаг газар</b> /ripianMeadow/	Голын хөвөө дагуу болон уул нуруу, даваа гүвээ зэрэг газрын хөндий дэх чийг ихтэй өвс, ногоо сайн ургадаг булан тохой газар, мараа шал.
13	<b>Газар тариалан</b> /cropland/	Тариа ногоо тариалах газар.
14	<b>Хот, суурин газар</b> /urban/	Хүн ам олноороо суурьшсан, барилга байшин, үйлдвэр, худалдаа, засаг захиргааны байгууллага төвлөрсөн газар.
15	<b>Усан орчин</b> /lakesRivers/	Байгалийн болон хиймэл усан орчин.

